

**МОНГОЛЫН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН МЭРГЭЖЛИЙН ХОЛБООДЫН
ЗӨВЛӨЛИЙН ДҮРЭМ
ГҮ ТББ**

Агуулга:

Нэг:	Нийтлэг үндэслэл
Хоёр:	Зөвлөлийн эрхэм зорилго, үйл ажиллагааны үндсэн чиглэл
Гурав:	Зөвлөлийн гишүүнчлэл, гишүүний эрх, үүрэг
Дөрөв:	Зөвлөлийн эрх барих дээд байгууллага
Тав:	Зөвлөлийн гүйцэтгэх дээд байгууллага
Зургаа:	Зөвлөлийн Ерөнхийлөгч, Дэд Ерөнхийлөгч, Нарий Бичгийн Дарга
Долоо:	Зөвлөлийн гишүүд
Найм:	Хяналтын зөвлөл
Ес:	Зөвлөлийн ажлын алба
Арав:	Зөвлөлийн санхүүжилт
Арван нэг:	Зөвлөлийн дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах, Зөвлөлийн үйл ажиллагааг зогсоох тухай
Хавсралт:	МАЖМХЗ-ийн гишүүний ангилал, хоорондын ялгаа, татварын хэмжээ

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1. Байгууллагын албан ёсны нэр “ Монголын Аялал Жуулчлалын Мэргэжлийн Холбоодын Зөвлөл” гэх ба цаашид МАЖМХЗ гэж товчлон нэрлэнэ.
- 1.2. МАЖМХЗ нь Монгол улсад аялал жуулчлалын салбарт үндсэн үйл ажиллагаа явуулж буй болон салбарт оролцоотой өөр бусад үйлчилгээ эрхэлдэг гишүүд бүхий мэргэжлийн холбоодуудаас бүрдсэн гишүүнчлэлийн тогтолцоо бүхий гишүүддээ үйлчилдэг төрийн бус байгууллага мөн.
- 1.3. МАЖМХЗ нь бие даан өөрөө өөрийгөө санхүүжүүлэгч байгууллага бөгөөд Монгол улсын төрийн бус байгууллагуудын тухай хууль, энэхүү дүрмийг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон Монгол улсын холбогдох хууль, тогтоомжийн хүрээнд үйл ажиллагаагаа явуулна.
- 1.4. МАЖМХЗ нь өөрийн тамга тэмдэг, бэлэгдэл, албан бичгийн нүүр, харилцах данс, зар сурталчилгааны логотой байна.
- 1.5. МАЖМХЗ-ийн санхүүгийн жил 1-р сарын 1-нээс 12-р сарын 31 хүртэл үргэлжилнэ.

Хоёр. Зөвлөлийн эрхэм зорилго, үйл ажиллагааны үндсэн чиглэл

- 2.1. МАЖМХЗ-ийн эрхэм зорилго нь Монгол улсад аялал жуулчлалын салбарт үйл ажиллагаа явуулж буй мэргэжлийн холбоодын чадавхийг дээшлүүлэх.
- 2.2. Аялал жуулчлалын салбарыг хөгжүүлэхэд нөлөөлөх шинэчлэл, өөрчлөлт, Төрийн бодлого шийдвэр, хууль, дүрэм, журам тогтоол гаргаж, батлуулаад мэргэжлийн холбоодын санал, шүүмжлэл, зөвлөмжийг өгдөг авдаг механизмыг бүрдүүлж ажиллах, төлөвшүүлэх.
- 2.3. Засгийн газраас баталсан тогтоолын дагуу төрийн зарим чиг үүргийг мэргэжлийн холбоодод шилжүүлэх ажлыг эрчимжүүлэх.

- 2.4. Мэргэжлийн холбоодын хамтын ажиллагаа, уялдаа холбоог сайжруулж, хууль эрх зүйн орчинг бүрдүүлж, холбоодын санал санаачлагыг холбогдох байгууллага, олон нийтэд сурталчилан таниулах.
- 2.5. Салбарын мэргэжлийн холбоодын үйл ажиллагааг дэмжин бодлогын болоод арга зүйн туслалцаа үзүүлэх, бодлого стратегид нэвтрүүлэн бодит ажил хэрэг болгох.
- 2.6. Мэргэжлийн холбоодын хууль ёсны бөгөөд нийтлэг эрх ашиг, сонирхлыг хамгаалж, Монголын аялал жуулчлалын салбараас улс орны нийгэм, эдийн засгийн хөгжилд оруулах үр ашгийг тогтвортойгоор нэмэгдүүлэхийн төлөө чармайн ажиллахад оршино.

Зөвлөл нь энэхүү эрхэм зорилгодоо хүрэхийн тулд дараахь үндсэн чиглэлүүдээр үйл ажиллагаа явуулна.

- 2.1.1. Монгол улсад аялал жуулчлал ба түүнд оролцоотойгоор үйл ажиллагаа явуулж буй мэргэжлийн холбоодын чадавхийг дээшлүүлэх үйл ажиллагааг эрчимжүүлэх, хамтын ажиллагааг бэхжүүлэх.
- 2.1.2. Хууль эрх зүйн болон бизнесийн шударга өрсөлдөөний таатай орчинг бий болгох чиглэлээр төр, засгийн байгууллагуудтай хамтран ажиллаж, салбарын хэмжээнд бодлого боловсруулахад идэвхтэй оролцох.
- 2.1.3. Мэргэжлийн холбоодын хууль эрх зүйн орчны бичиг баримтыг судлан үзэж, санал, дүгнэлт, зөвлөмжийг гаргаж холбогдох төрийн байгууллагад хүргэх.
- 2.1.4. Мэргэжлийн Холбоодын зөвлөлөөр дамжуулан салбараа төлөөлөн төр, засгийн байгууллагад асуудлаа уламжилж, шийдвэрлүүлэх түвшиний арга хэмжээ авах бодлого, стратегийн талаархи мэдээллээр тогтмол хангах.
- 2.1.5. Салбарын хэмжээнд тулгараад буй асуудлыг шийдвэрлэх зорилгоор уулзалт, ярилцлагыг зохион байгуулна.
- 2.1.6. Төрийн зарим чиг үүргийг мэргэжлийн холбоодын шилжүүлэх асуудлыг хөндөн, холбогдох төрийн байгууллагад уламжлах, уг асуудлыг идэвхжүүлэх, шаардлагатай чиг үүргүүдийг авах ажлыг зохион байгуулах.
- 2.1.7. Гишүүдээ олон улсын болон бүс нутгийн аялал жуулчлалын холбогдолтой мэдээллээр хангах
- 2.1.8. Салбарын хэмжээнд бизнесийн болон мэргэжлийн ур чадвар, бүтээгдэхүүний чанар, үйлчилгээний түвшинг дээшлүүлэх зорилгоор сургалт, семинар, хэлэлцүүлэг зохион байгуулах, холбогдох материалаар хангах.
- 2.1.9. Салбарт үйл ажиллагаа явуулж байгаа мэргэжлийн холбоодод өөр хоорондоо харилцан, хамтран ажиллах бололцоо олгосон тогтолцоог бий болгох.
- 2.1.10. Зөвлөлийн үйл ажиллагааг хэвлэл мэдээлэл, интернэт болон мэдэлийн бусад сувгаар дамжуулан сурталчлах.
- 2.1.11. Гишүүд өөр хоорондоо байнгын харилцатай байж, харилцан туршлага солилцох, хамтын ажиллагаанд дэмжлэг үзүүлэх.

Гурав. Зөвлөлийн гишүүнчлэл, гишүүний эрх, үүрэг

- 3.1. МАЖМХЗ-ийн дүрмийг хүлээн зөвшөөрсөн мэргэжлийн холбоод гишүүнээр элсэж болно.
- 3.2. Гишүүдийн татварын хэмжээ, хандивыг энэхүү дүрмийн хавсралтад тусгасан болно.
- 3.3. Гишүүд зөвлөлийн үйл ажиллагааг дэмжин ажиллах хүсэл эрмэлзэлтэй, бэлтгэлтэй байх бөгөөд дараахи үүргийг хүлээнэ. Үүнд:
 - 3.3.1. Зөвлөлийн дүрмийг дагаж мөрдөх.
 - 3.3.2. Гишүүний татварыг хугацаанд нь төлөх.
 - 3.3.3. Зөвлөлийн үйл ажиллагаанд идэвхтэй оролцох.

- 3.3.4. Зөвлөлийн хуралд идэвхтэй оролцох .
 - 3.3.5. Зөвлөлийн эв нэгдлийг хамгаалз, өөрийн ашиг сонирхол, нэр хүндийг гутаах аливаа үйл ажиллагааг явуулагүй байх.
 - 3.3.6. Зөвлөлийн нэр хүнд, эд хөрөнгө, ажлын байрыг улс төр, шашиг шүтлэг хувийн зорилгоор ашиглахгүй байх.
- 3.4. Зөвлөлд гишүүнээр элсэхийг хүсэгчид, Зөвлөлийн дүрэмтэй урьдчилан танилцаж, хүлээн зөвшөөрч буй тохиолдолд МАЖМХЗ-ноос бүртгэлийн маягт аван бөглөж, хүсэлтээ гаргах ба бүртгэлийн хураамж болон тухайн жилийн татварыг шууд төлнө.
 - 3.5. Зөвлөлийн гишүүний жилийн татвараа 3-р улиралд багтаан төлөх ба төлсөн байдлаас хамаарч гишүүнчлэлийн асуудлыг үргэлжлүүлэх буюу сэргээнэ. Гишүүний татвараа хугацаанд нь төлөхгүй нэг сар өнгөрвөл гишүүнчлэлийг нь хүчингүйд тооцно.
 - 3.6. Зөвлөлийн гишүүнээс татгалзах хүсэлтэй гишүүн энэ тухай өргөдлөө МАЖМХЗ-нд бичгээр мэдэгдэнэ.
 - 3.7. МАЖМХЗ-ын дүрэм болон Зөвлөлийн бодлогод харш үйл ажиллагаа явуулж байгаа гишүүний гишүүнчлэлийг татгалзуулах талаархи асуудлыг Холбооны Удирдах Зөвлөлийн хурлаар хэлэлцэж, холбогдох шийдвэрийг гаргана.

Дөрөв. Холбооны эрх барих дээд байгууллага

- 4.1. Холбооны эрх барих дээд байгууллага нь Зөвлөлийн Хурал байна .
- 4.2. Зөвлөлийн хурлыг улиралд нэг удаа хуралдуулна. Хурлын товыг Зөвлөлийн дарга зарлана.
- 4.3. Хурлын үйл ажиллагааг Зөвлөлийн Ерөнхийлөгч, Дэд Ерөнхийлөгч удирдан явуулна.

Зөвлөлийн хурал дараахи бүрэн эрхтэй.

- 4.4.1. Зөвлөлийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах.
- 4.4.2. Зөвлөлийн гишүүдийг сонгох, чөлөөлөх огцруулах.
- 4.4.3. Зөвлөлийг өөрчлөн байгуулах, татан буулгах.
- 4.4.4. Зөвлөлийн бодлогын асуудал болон үйл ажиллаганы төлөвлөгөөг хэлэлцэж батлах.
- 4.4.5. Зөвлөлийн төслийг батлах, санхүүгийн болон үйл ажиллагааны тайланг хэлэлцэж, дүгнэлт өгөх.

Тав. Холбооны гүйцэтгэх дээд байгууллага

- 5.1. Зөвлөлийн гишүүдийн хурлын хооронд зөвлөлийн үйл ажиллагааг түүний гүйцэтгэх байгууллага зөвлөлийн Ерөнхийлөгч, Дэд Ерөнхийлөгч, нарийн бичгийн дарга хэрэгжүүлнэ
- 5.2. Зөвлөл нь Зөвлөлийн Ерөнхийлөгч, Дэд Ерөнхийлөгч бусад зөвлөлийн гишүүдээс бүрдэнэ.
- 5.3. Зөвлөлийн Ерөнхийлөгч, Дэд Ерөнхийлөгчийн сонгуулийг дөрвөн жил тутамд явуулна.Зөвлөлийн гишүүд нь Зөвлөлийн гишүүн холбоодоос сонгогдоно.
- 5.4. Зөвлөлийн аль нэг гишүүн огцорсон, эсвэл өөр шалтгаанаар Зөвлөлд ажиллах боломжгүй бол нөхөн сонгуулийг цаг хугацаа хамаарахгүйгээр хийнэ.
- 5.5. Зөвлөлийн хурлыг Зөвлөлийн Ерөнхийлөгч эсвэл Дэд Ерөнхийлөгч удирдан гишүүдийн 50-аас дээш хувийн ирц бүрдсэн тохиолдолд хуралдуулж, шийдвэрийг энгийн олонхийн саналаар гаргана.
- 5.6. Зөвлөл дараахи эрхийг эдэлж, үүргийг хэрэгжүүлнэ.
 - 5.7.1. Зөвлөлийн үйл ажиллагааны төлөвлөгөө, төсвийг боловсруулж, бүх гишүүдийн хурлаар хэлэлцүүлэхэд бэлтгэх.
 - 5.7.2. Зөвлөлийн хуралд үйл ажиллагааны талаар тайлан тавих.
 - 5.7.3. Зөвлөлийн хурлаас гарсан шийдвэрийг хэрэгжүүлэх.

- 5.7.4. Зөвлөлийн Ерөнхийлөгч, Дэд Ерөнхийлөгч нарыг сонгоно.
- 5.7.5. Зөвлөлийн гишүүний нэр дээр Зөвлөлийн аль нэг гишүүнэс асуулт, санал эсвэл зөвлөмж ирсэн тохиолдолд энэ тухай Зөвлөлд мэдээлэх.
- 5.7.6. Зөвлөлийн аль нэг гишүүн чөлөөлөгдсөн эсвэл огцорсон тохиолдолд бүх бичиг баримт болон тайлан мэдээг нь түүний ажлыг хүлээн авч байгаа хүнд эсвэл Зөвлөлийн Ерөнхийлөгчид шилжүүлнэ.
- 5.7.7. Шагнал урамшууллын асуудлыг шийдвэрлэнэ.

Зургаа. Зөвлөлийн Ерөнхийлөгч, Дэд Ерөнхийлөгч, Нарийн Бичгийн Дарга

- 6.1. Зөвлөлийн Ерөнхийлөгч дараахи эрх, үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд:
 - 6.1.1. Зөвлөлийн албан ёсны төлөөлөгч бөгөөд төр, засгийн болон олон нийтийн байгууллагууд, мөн түүнчлэн олон улсын байгууллагуудтай холбоо тогтоох ба хамтран ажиллах ажлыг хариуцна.
 - 6.1.2. Зөвлөлийн Хурлаар хэлэлцэх асуудлаа бэлтгэсэн эсэхийг шалгаж баталгаажуулна. Зөвлөлийн жилийн нэгдсэн тайланг Зөвлөлийн Хуралд танилцуулна.
 - 6.1.3. Зөвлөлийн Ерөнхийлөгч нь өөрийн үйл ажиллагаатай холбоотой бүх бичиг баримт, захидал харилцааны хувийг МАЖМХЗ руу явуулах үүрэгтэй.
- 6.2. Дэд Ерөнхийлөгч нь дараахи эрх, үүргийг хэрэгжүүлнэ.
 - 6.2.1. Холбооны өдөр тутмын үйл ажиллагааг эрхлэх ажлын аппаратыг ажиллуулна.
 - 6.2.2. Зөвлөлийн санхүү, тайлан балансыг хариуцаж ажиллана.

Долоо. Зөвлөлийн гүйцэтгэх алба

- 7.1. Зөвлөлийн өдөр тутамын үйл ажиллагааг Зөвлөлийн нарийн бичгийн дарга эрхлэн явуулна.
- 7.2. Зөвлөлийн Ерөнхийлөгчийн санал болгосноор нарийн бичгийн дарга 4 жилийн хугацаатайгаар томилно.
- 7.3. Зөвлөлийн Дэд Ерөнхийлөгч Нарийн Бичгийн Даргатай гэрээ байгуулан ажиллана.

Найм. Удирдах Зөвлөлийн гишүүд

- 8.1. Аялал жуулчлалын салбарт идэвхитэй үйл ажиллагаа явуулж байгаа мэргэжилийн холбоод байна
- 8.2. Зөвлөлийн гишүүд дараахи эрх үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд:
 - 8.2.1. Зөвлөлийн гишүүд нь зөвлөлийн ажилын хэсгийн үйл ажиллагааг удирдаж ажиллана.
 - 8.2.2. Хариуцсан ажлын хэсгийн хурлыг зохион байгуулна.
 - 8.2.3. Ажлын хэсгийн хурал дээр ярилцсан ба хөндөгдсөн бүх асуудлыг Зөвлөлд танилцуулна.
 - 8.2.4. Сонгуульт хугацааны үед Зөвлөлийн Ерөнхийлөгч, Дэд Ерөнхийлөгч сонгох, сонгогдох эрхтэй.

Ес. Хяналтын зөвлөл

- 9.1. Хяналтын зөвлөл нь 3 гишүүнээс бүрдэх ба зөвлөлийн хурлаас 4 жилийн хугацаатай сонгогдоно.
- 9.2. Хяналтын Зөвлөлийн гишүүд хяналтын зөвлөлийн даргыг сонгоно.
- 9.3. Хяналтын зөвлөл зөвлөлийн санхүүгийн үйл ажиллагаа болон дүрмийн биелэлтэд хяналт тавина.
- 9.4. Тайлангаа зөвлөлийн хуралд илтгэн танилцуулж байна.

Арав. Зөвлөлийн санхүү

- 10.1. Зөвлөлийн орлого нь гишүүдийн жилийн татвар, өөр бусад байгууллага, хувь хүмүүсийн хандив, Зөвлөлийн дүрэм заасан зорилгоо хэрэгжүүлэхтэй холбогдсон аж ахуйн үйл ажиллагаа, үйлчилгээнээс орсон болон бусад орлогоос бүрдэнэ.
- 10.2. Зөвлөлийн гишүүдийн татварын талаар гаргасан өрчлөлт бүхийг хүчин төгөлдөр болохоос нэг сарын өмнө бүх гишүүдэд зарлан мэдэгдэнэ.
- 10.3. Зөвлөлийн мөнгөн хөрөнгө нь Улаанбаатар хот дахь найдвартай банкны дансанд МАЖМХЗ-ийн нэр дээр хадгалагдана.
- 10.4. Зөвлөл нь ТББ-ын хуульд заасны дагуу жилийн санхүүгийн тайлан тэнцлийг гаргаж татварын албанд хүргүүлнэ.
- 10.5. Зөвлөлийн мөнгөн хөрөнгө , эд хөрөнгийг хувийн зорилгоор ашиглахыг хориглоно.
- 10.6. Зөвлөлийн санхүүгийн тайланг жил бүр гаргаж Санхүүгийн хяналтын зөвлөл хөндлөнгийн хяналт хийнэ.

Арван нэг. Зөвлөлийн дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах, Зөвлөлийн үйл ажиллагааг зогсоох тухай

- 11.1. Зөвлөлийн дүрэмд нэмэлт төслийг бүх гишүүдэд нэг сарын өмнө урьдчилан тарааж танилцуулсан байх ба асуудлыг зөвлөлийн гишүүдийн хурлаар авч хэлэлцэх эсэх болон холбогдох шийдвэрийг хуралд оролцогчдын энгийн олонхийн саналаар шийдвэрлэнэ.
- 11.2. Зөвлөлийг татан булгасан тохиолдолд бүх төлбөр тооцоог барагдуулсны дараа үлдсэн мөнгөн сан, эд хөрөнгийг түүнийг залгамжлагч байгууллага , хэрэв тийм байгууллага байхгүй бол ижил төстэй зорилго, зорилт бүхий төрийн бус байгууллагад шилжүүлнэ.

ХАВСРАЛТ

1. **Гишүүнчлэл. МАЖМХЗөвлөлийн дүрмийн зохих шаардлагыг хангасан аялал жуулчлалын салбарт идэвхитэй үйл ажиллагаа явуулж байгаа мэргэжлийн холбоод байна.**
2. **Мэргэжлийн холбоодын зөвлөлд жилд төгрөгийн гишүүний татвар төлөх ба зохих хандив өргөж болно.**